## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 20 өдөр | Дугаар А/750 | Булган сум

Үсчин, гоо сайханчдын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 181.1.6, 18.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотод 2024 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Монгол бөхийн өргөөнд зохион байгуулагдах "Монголын үсчин, гоо засалч, хумс урлаачдын 2024 оны улсын аварга шалгаруулах тэмцээн"-д аймгийн төлөөллийг зохион байгуулалттай оролцоход дэмжлэг үзүүлсүгэй.

2.Булган аймгийн үсчин, гоо сайханчдын мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, шинэ техник технологид суралцахад шаардлагатай 3,900,000 (гурван сая есөн зуу) төгрөгийн дэмжлэгийг Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлын 16-д тусгагдсан Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011078